

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 17-ны өдөр

Дугаар

БА - 012/2025

Улаанбаатар хот

Нэг Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 8 (найм) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 120 (нэг зуун хорь) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 сарын 25-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/07/07 огноо, 0013150 дугаар, БАЗГ2023/431

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: ХД-03/23

2.3. Захиалагч: Иргэн Бууж овог, Санжаасүрэн эцэг эхийн нэр, Долзодмаа өөрийн нэр, Х359100861 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 9 дүгээр хороо, Алтайн 3-62 тоот, 99132906, холбоо барих утас, otgontsetsegvaanjil@gmail.com цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Ашид Ундрага Инженеринг ХХК оноосон нэр, 9011582060 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6437168 регистрийн дугаар, БУ19-575/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 9 дүгээр хороо, 7-р хороолол, Алтайн гудамж 433 байр Ү-5 тоот, 88016789 холбоо барих утас,

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Эрчимт Оч ХХК оноосон нэр, 9011155134 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5247489 регистрийн дугаар, БА-6.4 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 8 дугаар хороо, Баянцагааны 10-286, 99164434, 80091014 холбоо барих утас, erchimt-ohc@yahoo.com цахим хаяг;

Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Дабл Линк дизайн ХХК оноосон нэр, 9011295128 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5495148 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, 2-р хороолол 44-12 тоот, 98668228, 99148299 холбоо барих утас,

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтанд
оруулах комисс

Дэлгэрмөрөн инженеринг ХХК оноосон нэр, 9011487132 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5850703 регистрийн дугаар, БА-8.1 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо, бага дарь эх 7,1894 тоот 88118684,99116263 холбоо барих утас,

Мастервинд солюшн ХХК оноосон нэр, 9011499005 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5867067 регистрийн дугаар, БА-2.2.2 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, Алтайн 5-139 тоот, 88662609, 99261169 холбоо барих утас,

Эс Ди Эл ХХК оноосон нэр, 9011215111 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5348242 регистрийн дугаар, ТЗ-5.1 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, туул гол 72,301 тоот, 91904449 холбоо барих утас,

Би жи эй проперти ХХК оноосон нэр, 9011821237 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6614752 регистрийн дугаар, БА-3.5 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 1 дүгээр, хороо, 120 мянгат, 4,8 тоот, 10-286, 99035515 холбоо барих утас,

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Хархорум дизайн ХХК оноосон нэр, 9011568060 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5997585 регистрийн дугаар, ЗТ-6.1, ЗТ-6.2 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 8 дугаар хороо сонсголон 1.11 тоот, 99161124 холбоо барих утас,

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Иргэн Бууж овог, Санжаасүрэн эцэг эхийн нэр, Долзодмаа өөрийн нэр, Х359100861 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 9 дүгээр хороо, Алтайн 3-62 тоот, 99132906 холбоо барих утас, otgontsetsegvaanjil@gmail.com цахим хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул



- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 8 (найм) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 120 (нэг зуун хорь) айлын орон сууцны зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 8 (найм) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 120 (нэг зуун хорь) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

АЛТ ШАЛГА
ГАЗАР
байгууламжийг
орлуулах коми

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Иргэн С.Долзодмаагийн захиалгатай,
зоорьтой 16 давхар 1 блок, 8 (найм) автомашины дулаан зогсоолтой,
үйлчилгээтэй 120 (нэг зуун хорь) айлын орон сууцны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын
газрын Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч:




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Захиалагч Иргэн С.Долзодмаагийн
итгэмжилсэн төлөөлөгч

(В.Отгонцэцэг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын
биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



ТЫН

шиглалтанд
с

СҮХБААТАР ДҮҮРГИЙН 9 ДҮГЭЭР ХОРОО, ИРГЭН С.ДОЛЗОДМААГИЙН
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 16 ДАВХАР 1 БЛОК, 8 АВТОМАШИНЫ ДУЛААН
ЗОГСООЛТОЙ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 120 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот


Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Иргэн С.Долзодмаагийн захиалагатай, зоорьтой 16 давхар 1 блок, 8 автомашины дулаан зогсоолтой, 120 айлын үйлчилгээтэй орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын зааланд 1 дүгээр давхрын Ү-3 өрөөнд 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр 10:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11:50 цагт дуусав.

Хуралд:

- | | |
|---|----------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | Б.Батчимэг |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Захиалагч Иргэн С.Долзодмаагийн Итгэмжилсэн төлөөлөгч | В.Отгонцэцэг |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилга техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч | Г.Батбаатар |
| 4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | З.Очирпүрэв |
| 5. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК, шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн дарга | Д.Сүхбат |
| 6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер | Ц.Билэгт |
| 7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК, ерөнхий инженер | Н.Болор-Эрдэнэ |
| 8. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер | Б.Жамбалцанжид |
| 9. Онцгой байдлын ерөнхий газар, барилгын зураг төслийн хяналтын тасаг, Дэд хурандаа | Ч.Артаг |
| 10. Үндэсний Төв Архив, Архивын эрхлэгч | Я.Чулуун |
| 11. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн | О.Ундрах |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан | Н.Эрдэнэтөгс |
| 13. Тэлмүүн орд ХХК-ийн захирал | Х.Гантүшиг |
| 14. Хархорум дизайн ХХК-ийн архитектур | А.Баярсайхан |
| 15. Ашид ундрага инженеринг ХХК-ийн захирал | А.Чаминчулуу |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 15
- Хүрэлцэн ирсэн - 15



- **Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15**

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Иргэн С.Долзодмаагийн захиалагатай, зоорьтой 16 давхар 1 блок, 8 автомашины дулаан зогсоолтой, 120 айлын үйлчилгээтэй орон сууцны барилгын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын Улсын /ахлах/ байцаагч

Г.Батбаатар:

- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрээр үзүүлэх
- ЗТЗ-ийн ТЗ-ийг үзүүлэх
- D типийн лифт талын хананд ЗТ тусгасаны дагуу дуу тусгаарлагч хийх
- Айлуудын тагтны тусгаарлах хэсгийг зурагт өгсний дагуу өрлөг хийх
- Дээврийн ус зайлуулах хоолойд шүүр хийх
- Техникийн давхарын борооны ус зайлуулах хоолойг доош нь буулгах
- Гадна зогсоол дулаан зогсоолд тэмдэг тэмдэглэгээ хийх
- Суурийн ажил хийсэн үеийн ажлын актыг фото үзүүлэх
- ЗТЗ-г зурагт өөрчлөлт оруулсан гүйцэтгэлийн зургаа баталгаажуулан үзүүлэх
- Үйлчилгээний хэсэгт ХБИ-зориулсан ОО-н тоноглол хийх
- Заслын ажлыг бүрэн дуусгах / плита чигжээс хийх/
- Цонхны гадна усны хаялага хийж дуусгах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Узель хаягжуулалт хийх
- Узелийн өрөөнд ус зайлуулах трап хийх
- Гражид өндөрийн хязгаарлалт хийх
- Айлуудын плитаны чигжээс хийх
- Халаах хэрэгсэлд термостат хийх
- Алчуур хатаагчны төгсгөлд хий авагч үзлэгийн ревиз хийх
- Үнэр гаргагч бүрэн дулаалах
- 1-р давхарын АС-ийн механик систем зургийн дагуу бүрэн угсрах
- Дотор сангийн хэрэглэсэн материалын чанар / сертификат/ шалгуулах
- Ариун цэврийн өрөөний агааржуулалт сэнстэй решотиг угсрах
- Гадна, дотор ус, дулаан салхивчны ил, далд сорилт туршилтын акт шалгуулах
- Ундны усны нөөцийн сав ариутгал хийлгэж уснаас дээж авч шинжилгээнд өгч НЭМГ-ын байцаагчаар дүгнэлт гаргуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн дарга **Д.Сүхбат:**

- Холигч насосны узельд хаягжуулалт хийж өгөх

ХЯН

Барилга б

- Халаах хэрэгсэлд тохируулах хаалт тавих
- Давхар бүрийн халаалтын коллектор цэвэрлэгээ хийх
- Фото зураг авч үзүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, техник хяналтын инженер **Ц.Билигт**:

- Цахилгааны өрөөний хаалганд хаяг плакат хийх
- Цахилгааны самбаруудад хаяг, бичлэг схем, вирк хийх
- АВР болон үйлчилгээний тоолуур лацдуулах
- В1 давхар, цахилгааны самбарын гүйцэтгэлийн зураг үзүүлэх
- Эрчим хүчний тухай хуулийн 30.1.13 заалтыг хэрэгжүүлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК, инженер **Н.Болор-Эрдэнэ**:

- Зоорийн давхрын холбооны өрөөг хаягжуулах
- Хяналтын камерийн бичлэгийг 1сар хадгалдаг байхаар хардны багтаамжийг нэмэгдүүлэх
- Домофоны харилцуурыг хэвийн ажиллагаанд оруулах. Зурагт дэлгэцтэй домофон угсралтад харилцуур байна. Захиалагч, зохиогчоос тайлбар ирүүлэх, дүгнэлтэд өөрчлөлтийг тусгаж өгөх
- Дутуу суурилуулсан камериудыг суурилуулах зургаар 1давхарт 8ш, зоорийн давхарт 2ш суурилуулахаар тусгасан байна
- Харуулын өрөөнд камерийн хяналтыг зориулалтын цоожтой ранканд суурилуулах. Зурагт 3ш дэлгэц суурилуулахаар тусгасан. Угсралтад 1ш, дэлгэц суурилуулсан байна өөрчлөлтийг авторын дүгнэлтэнд тусгах

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Ус суваг удирдах газар, хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер **Б.Жамбалцанжид**:

- Цэвэр усны шугам дээр тэмдэг тэмдэглэгээ суурилуулах мөн хэмжих хэрэгсэл суурилуулах
- Гадна ЦУХ-т галын гидрант суурилуулах
- Саруул-Оч ХХК-тай болон Оймон ХХК-тай зөвшилцсөн албан бичгийг үзүүлэх
- Бохир усны гаргалгаа худгийн тагийг стандарт болгож дулаалга хийх. Холбох худгийг ил гаргах
- Усны тоолуурыг доош нь буулгаж заалт авах нөхцөлөөр хангах
- Холбогдох бичиг баримтыг бүрдүүлж гэрээ хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Онцгой байдлын ерөнхий газар, Гал түймэртэй тэмцэх газар, Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн барилгын зураг төсөл хяналтын тасаг, дэд хурандаа **Ч.Артаг**:

- Галын дотор усны даралтад цэгийн холбох тотго хошууг солих / D51мм-ийн / Багданов төрлийн
- Зоорийн давхарт авто зогсоолын тоог тавих / 8машин/
- Зоорийн давхарт болон 1-р давхарт гонхонд зургийн дагуу галд тэсвэржилтэй ган хаалга зургийн дагуу хийх
- Гадна талбайд байгаа 2-р давхар барилга дээр холбогдох бичиг баримт болон тайлбар албан бичиг өгөх
- Цэвэр усны нөөцийн сав зургийг 39.60 м3 сав байна. Одоо байгаа багасгасан байна. Зургийн дагуу засах. Усны тооцоо, даралтыг хэмжих

- Орон сууцны 2-р айлын дундах тусгаарлах ханыг зургийн дагуу засах. Гипс хийсэн байна. / Нөхөж үзүүлэх /
- Техникийн давхарт байгаа утаа мэдрэгчийн байрлалыг өөрчилөх
- Барилгын гадна дулаалга материал шинжилгээнд өгч дүгнэлт гаргуулах / ОБЕГ-ын ТСҮ хүрээлэн /
- Авто зогсоолд БНБД 21-05-10-ын дагуу авто зогсоолын норм дүрэм хангаж байгаа эсэх зохиогч тайлбар албан бичиг өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч **Я.Чулуун:**

- Архивд зураг төслийн баримт бичиг хүлээлгэн өгөх нийтлэг жагсаалтын дагуу баримтаа бүрэн бүрдүүлэхэд эх хувийг хүлээлгэж өгөх
- Хувийн хэрэг болон үндсэн баримтаа архивын заавар журмын дагуу цэгцлэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн, **О.Ундрах:**

- Техникийн давхарын усны хаялганы буултыг хийж, дотуур усны хаялганы хог шүүгч тавих
- Дээврийн мембраман материалыг хар цаас болгож өөрчилсөн тухай зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгаж ирүүлэх
- D сууцны лифтний хананд зураг төслийн дагуу тусгаарлагч хийх
- Цонх зураг төсөлд 3 давхар шиллэгээтэй гэж заасан 2 давхар хийсэн талаар зохиогч байгууллага дулаан техникийн тооцоо гаргаж, тайлбар, албан бичиг ирүүлэх
- Цонхны гадна талын усны хаялганы төмөр тавцанг гүйцээж хийх
- Барилгын тухай хуулийн 5.7.1-р заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Н.Эрдэнэтөгс:**

- Гадна авто зогсоолд батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу ХБИ-зориулсан зогсоолыг стандартын дагуу босоо болон хэвтээ тэмдэг тэмдэглэгээ хийх
- Гаднах явган хүний заманд брожурт налуулга хийж өгнө / зориулалтын /
- Үүдний довжооны налуу замын гадна хэсгийг халтардаггүй материалаар хийж налуулган градусыг стандартын дагуу болгох
- Мөн ямар ч доголгүй 1 түвшинд болгоно / гадаргууг /
- 1 давхарын үйлчилгээний ариун цэврийн өрөөнүүдэд ХБИ-зориулсан стандартын тоноогоор угаалтуур, суултууруудыг тоноглох 3н өрөөг

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Ашиглалт харицах байгууллага, Тэлмүүн орд ХХК-ийн захирал **Х.Гантүшиг:**

- ЦДДТ-ийн тоног төхөөрөмжийг виркжүүлэх хаяг хийх
- Ариутгах татуургын гаргалгааны 1-р худагт стандартын таг хийж, лайдаж цэвэрлэх
- Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд оруулах саналтай байна

АЛТЫН

Ашиглалта
ИСС

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтанд авах санал өгсөн.

Зураг төсөл зохиогч байгууллага, ХарХорум Дизайн ХХК-ийн Архитектор **А.Баярсайхан:**

- Гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр ашиглалтанд авах саналтай байна

Барилгын ажлын гүйцэтгэгч байгууллага, Ашид Ундрага Инженеринг ХХК-ийн захирал **А.Чаминчулуу:**

- Үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулахыг дэмжиж байна

Захиалагч байгууллагын төлөөл **В.Отгонцэцэг:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаварын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг:**


- Шатны хонгилын шатны хашлага зургийн дагуу болгох
- Давхар бүрт 4 айлын тагтны тусгаарлах ханыг зураг төслийн дагуу хийх
- Зоорийн давхарт өөрчилөлт шинээр хийсэн агуулахыг буулгаж зургийн дагуу зогсоолыг хийх
- Барилгын баруун талын барилгын түр хашааг стандартын дагуу шинэчлэх засварлах
- Нийт 120 айлын тагтны вакум хаалт, саравчын хоорондын ихтэй суурьлуулсан угсралтыг засварлах
- БТХ-ийн 14.3, 14.6 заалтын дагуу чанарын баталгаа гаргах
- Дутуу хийгдсэн ажлыг гүйцээж дүгнэлт шинэчилж ирүүлэх /зохиогч, захиалагч/

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Иргэн С.Долзодмаагийн захиалагатай, зорьтой 16 давхар 1 блок, 8 автомашины дулаан зогсоолтой, 120 айлын үйлчилгээтэй орон сууцны барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:

Захиалагч Иргэн С.Долзодмаагийн
итгэмжилсэн төлөөлөгч

(В.Отгонцэцэг)

